

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудитын хийсэн санхүүгийн тайлан.....	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаал.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/846
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хөдөө аж ахуйн их сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй..

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирал Т.Хэрүүга Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн анхан шатны баримтын бүрдэл хангасан баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байх, дотоод хяналтын системийг сайжруулах боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хөдөө аж ахуйн их сургууль санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2 үе шатаар гүйцэтгэсэн ба завсар үеийн аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 22-ноос 12 дугаар сарын 06-ны хооронд, жилийн эцсийн тайлангийн аудитыг 2020 оны 2 дугаар сарын 12-ноос 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Пантер мидланд аудит” ХХК-ийн аудитор Д.Билэгсайхан, Л.Оюун-Эрдэнэ, чанарын хяналтын менежер Б.Бямбасүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөө аж ахуйн их сургууль нь 2019 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газар, “Пантер мидланд аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 1/97 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөө аж ахуйн их сургууль нь Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д "...Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино..." гэж заасны дагуу "Амьдралын ухаан, байгаль орчны тэргүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, сургалт, үйлдвэрлэл, бизнесийг хосолсон бүс нутгийн манлайлах сургууль болно" гэсэн эрхэм зорилгын хүрээнд суралцагчдыг шинжлэх ухааны судалгааны ололтуудтай танилцуулан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглаж бие даасан судалгаа хийх дадалд сурган олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх зорилт тавин үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн удирдах зөвлөлийн 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Хөдөө аж ахуйн их сургуулийн дүрмийг баталсан .5-д "...Их сургууль нь үндсэн үйл ажиллагааны хувьд ашгийн төлөө бус байгууллага бөгөөд зардлаа нөхөх санхүү, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, суралцагч, багш, ажиллагсдын, ажиллах амьдрах орчин, нөхцөл, материаллаг хангамжийг дээшлүүлэх, мэдлэгийн үйлдвэрлэл, бизнес болгох чиглэлээр холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулна..." гэж заасан байна.

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн их сургуулийн Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/737 тоот Төрийн өмчит их сургуульд мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулж, 2019 оны 12 дугаар сарын 20-ны дотор дуусгаж батлуулах тушаал гарсан. Тушаалын дагуу ажлын хэсэг ажиллаж Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж дууссан боловч холбогдох байгууллагад бүртгүүлж баталгаажуулаагүй байна.

Хөдөө аж ахуйн их сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Unicus" программ хангамж ашигладаг байна. 2019 оны санхүүгийн тайланд бүрэлдэхүүн салбар болох Суурь боловсролын төв, Эдийн засаг, бизнесийн сургууль, Мал эмнэлгийн сургууль, Агроэкологийн сургууль, Инженер техникийн сургууль, Мал аж ахуй биотехнологийн сургуулиудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаж үзлээ. Хөдөө аж ахуйн их сургууль нь 2019 онд дотоод аудитын мэргэжилтэнг томилон ажиллуулсан бөгөөд дотоод аудитын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу ажилласан байх тул гүйцэтгэлийн үе шатанд "хангалттай" гэж үзсэн болно.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөдөө аж ахуйн их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 56,615.9 сая төгрөгөөс тооцон 566.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээг өөрчлөөгүй, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүн 50,587.8 сая төгрөгөөс 1 хувиар тооцож түвшинг 505.8 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,028.1 сая төгрөгөөр буюу 10.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2 040,3	674,6	-1 365,7
Авлага	4 551,8	2 032,9	-2 518,9
Урьдчилгаа	68,6	76,4	7,8
Бараа материал	2 152,9	2 147,7	-5,2
Үндсэн хөрөнгө	47 802,4	45 656,2	-2 146,2
Нийт хөрөнгө	56 616,0	50 587,8	-6 028,2
Өр төлбөр	249,8	2 614,9	2 365,1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	56 366,1	47 972,9	-8 393,2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	56 615,9	50 587,8	-6 028,1

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө 1,365.7 сая төгрөгөөр буурсан арилжааны банкинд байршуулсан хадгаламжийн хугацаа дуусаж, зарцуулсан нь нөлөөлсөн байна. Өмнөх онд тус сургуулийн 60 жилийн ой болсонтой холбогдуулан аж ахуйн нэгж байгууллага, багш, ажиллагсад, төгсөгчдөөс хандив өгсөн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Авлага 2,518.9 мянган төгрөгөөр буурсан нь Боловсролын тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт орж төрийн өмчит их дээд сургуулиудын тогтмол зардлыг олгохгүй болсонтой холбоотойгоор БСШУСЯ-наас авах 1,213.1 сая төгрөгийн санхүүжилтийн

авлагыг хаасан, мөн сургалтын төлбөрийн орлогыг өмнөх онд хичээлийн жилээр үүсгэж байсан ба 2019 онд период буюу богино улирлын системд шилжсэнтэй холбоотойгоор сургалтын төлбөрийн авлага 1,884.4 сая төгрөгөөр буурч, урьдчилж орсон орлого 2,432.2 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх онд үүссэн цалин, томилолт, бараа материал бэлтгэх урьдчилгааны барагдуулаагүй 120.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгааг анхаарч, барагдуулах шаардлагатай байна.

Үндсэн хөрөнгө 2,146.2 сая төгрөгөөр буурсан нь 2018 онд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант онд хөрөнгө оруулалтаар 424.2 сая төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 343.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. Данснаас үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,393.1 төгрөгөөр буурсан нь тайлант онд санхүүгийн үр дүнгийн тайлангаар 7,179.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь нөлөөлсөн байна.

Мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 1,213.1 сая төгрөг нь БСШУСЯ-аас авах тогтмол зардлын санхүүжилтийн авлагыг хаасантай холбоотой байна.

2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Хөдөө аж ахуйн их сургуулийн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 2019 оны төсвийг баталсан бөгөөд зарим орлого өссөнтэй холбоотойгоор 2019 оны 12 дугаар сарын 10-нд Удирдах зөвлөлийн тогтоолоор 2019 оны орлого, зарлагын төсөвт тодотгол хийсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2019 онд нийт орлого 21,494.0 сая төгрөг буюу 100.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт орлогын 67.7 хувь буюу 14,542.2 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу бакалаврын сургалтын орлого, 11.2 хувь буюу 2,398.3 сая төгрөгийг төсөл хөтөлбөрийн орлого, 9.3 хувь буюу 2,000.0 сая төгрөгийг банкны зээл, 6.5 хувь буюу 1,389.6 сая төгрөгийг бүрэлдэхүүн сургуулиудын орлого, 5.4 хувь 1,164.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Орлогын гүйцэтгэл

№	Ангилал	2019 оны орлогын төлөвлөгөө /сая.төг/	2019 оны орлогын гүйцэтгэл /сая.төг/	Хэтрэлт, хэмнэлт /сая.төг/
1	Бакалаврын сургалтын орлого	14 542,1	14 542,1	0,0
2	Туслах үйл ажиллагаанаас орох орлого	1 060,6	1 164,0	103,4
3	Төрөөс болон бусад санхүүжилтийн орлого /Банкны зээл/	2 000,0	2 000,0	0,0
4	Бүрэлдэхүүн сургуулиудын орлого	1 389,6	1 389,6	0,0
5	Төсөл хөтөлбөрөөс олох орлого	2 400,0	2 398,3	-1,7
	НИЙТ ОРЛОГО /1-5/	21 392,3	21 494,0	101,8

2019 оны нийт зардал төсвийн гүйцэтгэлээр 22,859.8 сая төгрөг буюу 100.3 хувьтай байна. Зардал 0.3 хувиар буюу 57.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь 2019 онд Хөдөө аж ахуйн их сургуулийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт орж тэтгэвэрт гарсан албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламж нэмэгдсэн, мөн цахилгаан, цэвэр бохир усны үнэ тариф нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Хүснэгт 3. Зардлын гүйцэтгэл

№	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт +/-	Тайлбар
НЭГ. СУРГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ШУУД ЗАРДАЛ					
1	Цалин, хөлс	12 240,0	12 236,3	3,7	
2	Нийгмийн даатгалын шимтгэл	1 515,0	1 511,3	3,7	хэмнэсэн
3	Гэрэл цахилгаан	467,0	469,8	(2,8)	Цахилгааны үнэ өссөн
4	Цэвэр, бохир ус	305,0	307,9	(2,9)	Тарифт өөрчлөлт орсон
5	Дулаан	262,0	261,5	0,5	хэмнэсэн
6	Оюутны арга хэмжээ	110,0	108,5	1,5	хэмнэсэн
7	Хичээл үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	687,0	687,2	(0,2)	нэмэлтээр зардал гарав
8	Интернэт шуудан холбоо	100,0	99,7	0,3	хэмнэсэн
	Дүн	15 686,0	15 682,2	3,8	
ХОЁР. СУРГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ШУУД БУС ЗАРДАЛ					
1	Бичиг хэрэг	64,0	63,4	0,6	хэмнэсэн
2	Тээвэр шатахуун	70,0	69,3	0,7	хэмнэсэн
3	Ном хэвлэл болон хэвлүүлэх	75,0	74,5	0,5	хэмнэсэн
4	Сантехникийн материал болон багаж, техник хэрэгслийн засвар	83,1	83,4	(0,3)	хэмнэсэн
5	Цахилгааны материал болон тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар	80,0	78,3	1,7	хэмнэсэн
6	Барилгын засвар, материал	150,0	148,5	1,5	хэмнэсэн
7	Гадаад болон дотоод томилолт	245,0	243,1	1,9	хэмнэсэн
8	Гадаад арга хэмжээ, зочид төлөөлөгчийн хүлээн авах	50,0	50,6	(0,6)	хэмнэсэн
	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, төсөл	2 140,0	2 139,9	0,1	хэвийн
10	Зар сурталчилгаа	60,0	59,5	0,5	хэмнэсэн
11	Аудитын үйлчилгээ	30,0	28,7	1,3	хэмнэсэн
12	Магадлан итгэмжлэл, зэрэглэл тогтоох	90,0	71,7	18,3	хэмнэсэн
13	Төвлөрсөн арга хэмжээ болон баяр ёслолын арга хэмжээ	150,0	149,3	0,7	хэмнэсэн
14	Нэг удаагийн буцалтгүй дэмжлэг тусламж	124,8	193,7	(68,9)	2019 онд ХААИС-ийн хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт орж тэтгэвэрт гарч буй албан хаагчдын тэтгэмжийг нэмэв.
15	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	55,0	54,5	0,5	хэмнэсэн
16	Багшийг хөгжүүлэх сургалт, семинар	55,0	53,9	1,1	хэмнэсэн
17	Банкны зээл төлөлт хүүгийн хамт	2 100,0	2 102,8	(2,8)	Банкны хүүтэй холбоотой зардал
18	Аж ахуйн тооцоотой нэгжийн зардал	120,0	119,2	0,8	хэмнэсэн
19	Бусад	1 003,0	1 021,6	(18,6)	
	Дүн	6 744,9	6 805,9	(61,0)	
ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ					
1	Үндсэн хөрөнгө-барилга, байгууламж	4,0	3,9	0,1	хэмнэсэн
2	Үндсэн хөрөнгө-авто тээврийн хэрэгсэл	190,0	189,9	0,1	хэмнэсэн
3	Үндсэн хөрөнгө-тавилга эд хогшил	70,6	70,6	-	хэмнэсэн
4	Үндсэн хөрөнгө-багаж тоног төхөөрөмж	101,1	101,1	0,0	хэмнэсэн
5	Үндсэн хөрөнгө-биет бус хөрөнгө	6,0	6,0	-	хэмнэсэн
	Дүн	371,7	371,5	0,2	
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	22 802,6	22 859,6	(57,0)	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзвэл материаллаг дүнтэй хэлбэлзэл ихтэй орлого, зардлуудыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь өмнөх оноос 1,097.3 сая төгрөгөөр буурсан нь тус сургуульд 2018 онд бакалаврын 6300 оюутан суралцаж байсан бол 2019 онд 5300 болж буурсан, мөн оюутнуудын шилжилт хөдөлгөөн ихэссэн, төрийн өмчит их дээд сургуулиудын тогтмол зардлыг санхүүжүүлэх зардал батлаагүй, хандив тусламжийн орлого багассантай холбоотой байна.

Харин төсөл хөтөлбөрийн орлого өмнөх оноос 546.0 сая төгрөгөөр, батлагдсан төлөвлөгөөнөөс 848.4 сая төгрөгөөр, боловсролын зээлийн сангийн орлого өмнөх оноос 2,221.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Ажиллагсдын цалин хөлс, унаа хоол, цалингийн нэмэгдэл өмнөх оноос 228.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2019 онд багш нарт аттестатчилал хийгдэж 43 багшийн цол, зэрэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Байр ашиглалтын зардал буюу тогтмол зардал өмнөх оноос 97.7 сая төгрөгөөр өссөн нь Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгааны үнэ нэмэгдүүлсэн, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс Улаанбаатар хотын үйлчилгээний цэвэр, бохир усны төлбөрийг нэмэгдүүлсэн нь шалтгаалжээ. Хангамж, бараа материалын зардал өмнөх оноос 130.8 сая төгрөгөөр буурсан нь зардлыг бууруулж төсөвлөсөн, батлагдсан төсвийн хүрээнд захиран зарцуулсантай холбоотой байна. Төсөл хөтөлбөрийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор эрдэм шинжилгээний ажил, судалгаа, төслийн зардал мөн өссөн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатанд 5 чиглэлд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 212.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 19.8 сая төгрөгийн алдааг залруулж, 120.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 72.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Цалин, томилолт, бараа материал бэлтгэх урьдчилгааны өмнөх онд үүссэн 120.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, мөн хуулийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба өр төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага барагдуулах албан шаардлага өгсөн

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөдөө аж ахуйн их сургууль нь төсвийн ангиллаар Төсвийн захирагчийн ангилалд орж байгаа боловч 2018 онд Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 “Төрийн өмчийн бүх шатны сургуулийн тогтмол зардал...улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалтад өөрчлөлт орж 2019 оноос улсын төсөвт төрийн өмчит их дээд сургуулиудын тогтмол зардлыг санхүүжүүлэхгүй болсон тул улсын төсвөөс санхүүжилт хийгдээгүй байна. Тус сургуулийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас үзэхэд өөрөө өөрийгөө санхүүжүүлэн, удирдах зөвлөл нь төсөв, төлөвлөгөөг баталж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалтын шаардлагыг хангаж байна. Иймд тус

сургуулийн статус болон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодорхой болгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны www.shilendans.gov.mn сайтад 2019 онд байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний талаарх нийт 15 төрөлд 952 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгсөн ба 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

- ✓ Захиргаа аж ахуйн кассын тайланд анхан шатны баримтгүйгээр 0.7 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.
- ✓ Захиргаа аж ахуйн харилцах дансаар анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 29.7 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.
- ✓ Мал аж ахуй биотехнологийн сургуулийн харилцах дансаар анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 19.0 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн
- ✓ Эдийн засаг бизнесийн сургуулийн харилцах дансаар анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 3.0 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн
- ✓ Мал аж ахуй биотехнологийн сургуулийн бараа материалын тайлангаар анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 14.2 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн
- ✓ Эдийн засаг бизнесийн сургуулийн бараа материалын тайлангаар анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 4.2 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн
- ✓ Эдийн засаг бизнесийн сургуулийн албан томилолтын тооцоогоор 0.1 сая төгрөгийн байрны зардал, 0.3 сая төгрөгийн зам хоногийн зардлыг тус тус илүү олгосон.
- ✓ Агро экологийн сургуулийн Нийгмийн даатгалын НД-7, НД-8 тайлан зөрүүтэй, олгохоор тооцоолсон цалингийн хүснэгтээрх дүн нийгмийн даатгалын тайлан дахь цалингийн дүнгээс 0.8 сая төгрөгөөр зөрсөн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалт, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох” журмын 2.4-д “Албан томилолтоор явсан,

буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” мөн Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 301 дүгээр “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалын заалттай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл: Хөрөнгө шамшигдах, зардал буруу тооцогдох, төсөв хэтрэх;

3.1.3. Өгсөн зөвлөмж: Анхан шатны бүрдэл дутуу, баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх, холбогдох хууль, дүрэм журмын заалтыг мөрдөж ажиллах

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Хуулийг хэрэгжүүлж ажиллана

3.2 Залилангийн эрсдэлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Инженер техникийн сургуулийн харилцах данснаас нягтлан бодогч нь анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт 72.3 сая төгрөгийн гүйлгээ хийж хувьдаа авсан бөгөөд аудитын явцад бүрэн төлж барагдуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.13 “эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл: Хөрөнгө шамшигдах

3.2.3. Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулж, залилангийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана

3.3 Тайлант хугацаанд хугацаанд хэрэгжүүлэх үндсэн чиглэл

3.3.1. Илрүүлэлт:

1. 2019 оны нийт зардал төсвийн гүйцэтгэлээр 22,859.8 сая төгрөг буюу 100.3 хувьтай байна. Зардал 0.3 хувиар буюу 57.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Захиргаа аж ахуйн жолоочийн шатахууны зарцуулалтыг шалгаж үзэхэд 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй буюу зардалд илүү бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2. Эрсдэл: Батлагдсан төсөв хэтрэх, хөрөнгө шамшигдах, зардал буруу тооцогдох

3.3.3. Өгсөн зөвлөмж: Удирдах зөвлөлийн баталсан зардлын хүрээнд үйл ажиллагаагаа тооцож ажиллах, төсвийн хэтрэлт гаргахгүй байх, холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллах

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хуулийн заалтыг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитын хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
